



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн бүрэн эрхийн хүрээнд хийсэн аудитын тайлан



Орон нутгийн татварын орлогыг 2,217.9 сая төгрөгөөр давуулан биелүүлж, зарлагыг 7,238.3 сая төгрөгөөр хэмнэсэн ч нэгдсэн төсвийн нийт тэнцэл (2,930.9) сая төгрөг байна.

Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл

АГУУЛГА		
	Агуулга	3
<u>Тайлан бэлтгэсэн:</u>	Товчилсон үггазар	4
	Хүснэгтийн жагсаалт	5
	Графикийн жагсаалт	5
Дарга, тэргүүлэх аудитор	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	6-7
М.Батсуурь	Бүлэг 1. Аймгийн засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 90.4 хувь, аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.3 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.	8-11
Аудитын менежер	Бүлэг 2. Увс аймгийн нэгдсэн төсвийн 2025 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.	12-16
М.Бат-Амгалан		
Ахлах аудитор	2.1. Увс аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.	12-14
Т.Намжил	2.2. Увс аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн зарлагыг өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.	15-17
Аудитор		
Т.Амармэнд	Бүлэг 3. Орон нутгийн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 100.9 хувийн биелэлттэй байна.	18-21
Т.Батсүх	3.1. Орон нутгийн 2025 оны төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 2,217.9 сая төгрөгөөр буюу 106.5 хувиар биелүүлсэн байна.	18-20
	3.2. Орлогын бүх гүйлгээ тухайн Төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.	
2025 оны 04 дүгээр сар	Бүлэг 4. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,238.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	20-21
	4.1 Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,238.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	22-32
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7045-3317 дугаарын утсаар харилцана уу.	4.2. Бүтэц, орон тооны талаар:	
	Бүлэг 5. Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн нийт тэнцэл -2,930.9 сая төгрөг байна.	33
	5.1 Нэгдсэн төсвийн нийт тэнцэл -2,930.9 сая төгрөг байна.	
	5.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсөв 160.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.	34
	5.3. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө 2,662.7 сая төгрөгөөр тасарсан байна.	34-35
	5.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлого төлөвлөснөөс 685.2 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.	36-37
	5.5. Орон нутгийн төсөвт байгууллагуудад 7,656.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.	37-38
	5.6. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хуулийн зарим зүйл заалттай холбоотой зөрчил байна.	38-40
	5.7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	
	5.8. Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн	40-41
	5.9. Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.	42
	Дүгнэлт	43
	Зөвлөмж	44

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ:

1	УИХ	Улсын Их Хурал
2	ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
3	ЗДТГ	Засаг даргын тамгын газар
4	ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
5	УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	НА	Нийцлийн аудит
7	СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
8	ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
9	ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
10	АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
11	НТГ	Нэгдсэн төсвийн гүйцэтгэл
12	ЭМД	Эрүүл мэндийн даатгал
13	ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
14	ОН	Орон нутаг
15	ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
16	ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
17	БУА	Барилга угсралтын ажил
18	ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
19	ААН	Аж ахуйн нэгж
20	ЭМЯ	Эрүүл мэндийн яам
21	ЭМТ	Эрүүл мэндийн төв
22	СЭМТ	Сумын эрүүл мэндийн төв
23	ХШҮХ	Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтэс
24	ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
25	ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
26	ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
27	ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ .9	
Хүснэгт 2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээ	9
Хүснэгт 3. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдлаар уялдаа.....	10
Хүснэгт 4. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар уялдаа.....	10
Хүснэгт 5. Аймгийн 2025-2028 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөл хэрэгжилт, үнэлгэ	11
Хүснэгт 6. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ.....	11
Хүснэгт 7. Аймгийн орлогын бүрдүүлэлт	13
Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр	14
Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө.....	15
Хүснэгт 10. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл.....	18
Хүснэгт 11. Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрөөр бэлтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн зарцуулалт	23
Хүснэгт 13. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл	24
Хүснэгт 14. Аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээ	25
Хүснэгт 15. Аймгийн ОНХС-ийн хэрэгжээгүй төсөл арга хэмжээ, батлагдсан төсөв	27
Хүснэгт 16. Замын сангийн төсвийн гүйцэтгэл, үр дүн	28
Хүснэгт 17. Байгаль хамгаалах сангийн төсвийн гүйцэтгэл, үр дүн.....	29
Хүснэгт 18. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан УТХО, ОНТХО-аар хийгдэх төсөл, арга хэмжээний нэр, төсөвт өртөг	30
Хүснэгт 19. Орон тооны гүйцэтгэл дутуу байгууллагууд	31
Хүснэгт 20. Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэл	33
Хүснэгт 21. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Халамжийн сангийн гүйцэтгэл	34
Хүснэгт 22. Нийгмийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл	34
Хүснэгт 23. Нийгмийн даатгалын сангийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	35
Хүснэгт 24. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого	36
Хүснэгт 25. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг өмнөх оны харьцуулалт	36
Хүснэгт 26. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт	38
Хүснэгт 27. Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт	41
Хүснэгт 28. Ерөнхий чиглэлийн судалгаа	42

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Суурь орлогын бүрдүүлэлт /сая.төг/	14
График 2. Татварын орлогын эзлэх хувь	15
График 3. Бараа үйлчилгээний зардлыг нэр төрөл/ сая.төг/	17
График 4. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	19

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

1. Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийлээ.

- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлого, зарлагын төлөвлөлт
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн орлогын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын гүйцэтгэл
- Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, Халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын санг хамруулан судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

4. Аудитын арга зүй:

Аудитыг Монгол улсын Төрийн аудитын MNS 6817-4:2020, Санхүүгийн аудитын тулгуур зарчим, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Санхүүгийн тайлангийн аудитын заавар аргачлал”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагын 2025-2026 онд гүйцэтгэх аудитын ерөнхий чиглэл, 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”-ийн дагуу аудитын зорилго, зорилтын хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт боловсруулав.

Увс аймаг дахь Төрийн аудитын газраас аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн акт, албан шаардлага, зөвлөмжийг аудитын тайланд давхардуулан тусгаагүй болно.

5. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулж, чанарын хяналтыг хэрэгжүүлэн, багийг ахлах аудитор Т.Намжил ахалж, аудитор Т.Амармэнд, Т.Батсүх нар хийж гүйцэтгэлээ.

6. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- ❖ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ❖ Төрийн аудитын тухай хууль
- ❖ Төсвийн тухай хууль
- ❖ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ❖ Монгол улсын 2025 оны төсвийн тухай хууль
- ❖ Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль
- ❖ Нийгмийн даатгалын ерөнхий хууль
- ❖ Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль
- ❖ Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- ❖ Татварын багц хууль
- ❖ Шилэн дансны тухай хууль
- ❖ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”
- ❖ Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх аргачилсан зөвлөмж”
- ❖ Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх аудитад баримтлах ерөнхий чиглэл
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ❖ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ❖ Увс аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд
- ❖ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд

7. Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3 дахь заалтад “Төсвийн жилийн хязгаарт багтаасан байх” гэж заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулсан байна.

Аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалтад “Тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх” гэж заасны дагуу орон нутгийн 2025 оны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 115,365.7 сая төгрөгөөр, нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 115,365.7 сая төгрөгөөр баталжээ. 2025 онд нийт 104,300.2 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, 11,065.5 сая төгрөгийг урд оны үлдэгдэл, төсөвт байгууллагын өөрийн орлогоос санхүүжүүлэхээр баталсан байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу гаргаж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 8/516 дугаар албан бичгээр Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

“УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ийн ХЭРЭГЖИЛТИЙГ 90.4 ХУВЬ, БҮЛЭГ 1 АЙМГИЙН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ 87.3 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ ГЭЖ ДҮГНЭСЭН БАЙНА.

Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр “Аймгийн 2025 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд үндэслэн баталжээ. Үүнд: Аймгийн 2025 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 70,027.4 сая төгрөгөөр баталжээ.

“Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-г аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор баталсан байна. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 92 арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор “Увс аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг 4 бодлогын хүрээнд 100 зорилт, 20 төсөл, арга хэмжээ, 14 шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинтэйгээр баталсан байна.

Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, “Алсын хараа-2050”, Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол улсын хөгжлийн 2025 оны жилийн төлөвлөгөө, Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Увс аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг Увс аймгийн хүний хөгжлийн индексийг улсын дундаж түвшинд ойртуулахад чиглэсэн эдийн засгаа тэлэх, хүн төвтэй хөгжлийн тэргүүлэх төсөл, зорилт арга хэмжээнүүдийг дэвшүүлэхэд чиглүүлсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөвт тодотгол хийх тухай” 42 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүн, үр дүнгийн чанарын болон тоо хэмжээний шалгуур үзүүлэлтийг тусгасан байна. Үүнд: Аймгийн 2025 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг 57,423.7 сая төгрөгөөр баталжээ.

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10 дахь хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг даргын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг”, 9.10.1 дэх заалтад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцүүлэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван

жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын хамт тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 35 хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд дараах байдлаар тусгагдсан байна.

Хүснэгт 1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ

№	Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээ		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ	
	Санхүүжүүлэх эх үүсвэр	Хөтөлбөрийн тоо	Тусгагдсан	Орон нутгийн төсөвт
1	Орон нутгийн хөгжлийн сан	12	13	
2	Их засвар хөрөнгө оруулалт	9		13
3	Замын сангийн хөрөнгө оруулалт	1		1
4	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	1		1
5	Хөтөлбөр төсөл, арга хэмжээ	7		7
	Нийт	30	13	22

Эх сурвалж: Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө

Дээрх хүснэгтээс харахад Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтад аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 5 төсөл, арга хэмжээг баталсан байна. Үүнд:

Хүснэгт 2. Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	/сая.төг/ 2025 онд хэрэгжүүлэх дүн
		Эхлэх	Дуусах		
1	Улаангом сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлыг эхлүүлэх	2025	2026	1,500.0	300.0
2	Хүрэн морьтын давааны зам засвар /Малчин сумын/	2025	2025	90.0	90.0
3	Хар хэмийн амны зам засвар /Малчин сумын/	2025	2025	85.1	85.1
4	Хур хог булшлах, цэвэрлэх /Малчин сумын/	2025	2025	30.0	30.0
5	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Тэс сум 1-р баг/	2025	2025	300.0	300.0
	Нийт			2,005.1	805.1

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө

Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасныг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдлаар уялдсан байна.

Хүснэгт 3. Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй дараах байдлаар уялдсан байна.

№	Аймгийн засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан эсэх
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо	
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	
2	Хүний хөгжлийн бодлого	6	20
3	Эдийн засгийн хөгжил	8	9
4	Засаглалын бодлого	4	6
	Дүн	21	35

Эх сурвалж: Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар уялдсан байна.

Хүснэгт 4. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй дараах байдлаар уялдаатай байна.

№	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээтэй уялдсан
	Бодлого	Ерөнхий хөтөлбөрийн тоо	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	5
2	Хүний хөгжил	7	8
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	6	2
4	Эдийн засаг	6	2
5	Засаглал	6	3
6	Ногоон хөгжил	4	6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	5	2
8	Бүс, сум, орон нутгийн хөгжил	3	7
	Дүн	42	35

Эх сурвалж: Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Увс аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 63 дугаар тогтоолоор “Увс аймгийн Засаг даргын 2025-2028 онд

хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2025 оны хэрэгжилтийг 90.4 хувиар буюу “Үр дүнтэй хэрэгжсэн” гэж дүгнэжээ.

Хүснэгт 5. “Увс аймгийн Засаг даргын 2025-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилт, үнэлгээ

ЗДАУХ-ийн салбарын үр дүн	Нэг: Бүсчилсэн хөгжлийн бодлого - увс аймгийн тэргүүлэх зорилт					Хоёр: Хүний хөгжлийн бодлого					Гурав: Зэдийн засгийн хөгжил					Дөрөв: Засаглалын бодлого						
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22
Нийт арга хэмжээний тоо	183	7	24	13	13	15	10	7	7	14	21	6	4	4	2	4	12	4	9	4	6	12
Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь	90.7	66.7	86.1	91.7	89.8	88.9	95	100	57.1	100	82.3	100	86	100	100	75	87.3	100	98.1	100	100	100
Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж хувь	90.2	Нийт 2 үр дүн 64 шалгуураас ТЭЗ-ийн үр дүн: 91.2, хөтөлбөрийн үр дүн 89.1																				
Хэрэгжилтийн дундаж хувь	90.4	Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь 90.7, Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж хувь 90.2																				

Эх сурвалж: Аймгийг ЗДТГ-ын ХШҮХ-ийн тайлан, ИТХ-ын тогтоол

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 87.3 хувиар буюу “Үр дүнтэй хэрэгжсэн” гэж дүгнэжээ.

Хүснэгт 6. Аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ

Хөгжлийн жилийн төлөвлөгөөний салбарын үр дүн	Хөгжлийн жилийн төлөвлөгөөний салбарын үр дүн																		
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	
Нийт арга хэмжээний тоо	92	12	6	11	3	3	1	2	7	5	8	2	11	6	12	2	1	100	
Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь	89.6	85.5	85.7	100	90	100	100	100	89.76	100	100	0	100	83.3	99.1	100	100	100	
Шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж хувь	85.10	Нийт 3 үр дүн 58 шалгуураас Салбарын үр дүн: 84.2, ТЭЗ-ийн үр дүн: 85, хөтөлбөрийн үр дүн 86.09																	
Хэрэгжилтийн дундаж хувь	87.35	Төлөвлөгөөний хэрэгжилт 89.6, шалгуур үзүүлэлт 85.10																	

Эх сурвалж: Аймгийг ЗДТГ-ын ХШҮХ-ийн тайлан, ИТХ-ын тогтоол

**Бүлэг 2 УВС АЙМГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН 2025 ОНЫ ОРЛОГО,
ЗАРЛАГЫГ ӨМНӨХ ОНЫ ГҮЙЦЭТГЭЛД СУУРИЛАН ТӨЛӨВЛӨСӨН
БАЙНА.**

**2.1. Увс аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн орлогыг өмнөх оны
гүйцэтгэлийг суурь болгон төлөвлөсөн байна.**

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн хүрээнд Сангийн яамнаас төсвийн нийт орлого ба улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 69,036.7 сая төгрөгөөр хянасан байна.

Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/9591 дүгээр “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэл” болон өмнөх оны орлогын гүйцэтгэлийг тус тус үндэслэн 2025 оны орон нутгийн төсвийн орлогыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 50,689.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 119,725.8 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай” 37 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны төсвийн орлогыг 370.0 сая, зарлагыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Үүнд: Нэр заагдаагүй бусад орлогыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС болон их засвар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарим ажлыг хасаж, зарим ажлыг нэмж баталсан байна.

Дээрх төсвийн зохицуулалт нь Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх хэсэгт “Энэ хуулийн 42.2-т заасан төсвийн зохицуулалтыг хийхэд дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг авна”, 42.7 дахь хэсэгт “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Цаашид төсөвт зохицуулалт хийхдээ төсвийн тухай хуулийн 42.4, 42.7 дахь заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Улсын төсөвт тодотгол хийгдсэнтэй холбогдуулан Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Засаг дарга, хот, тосгоны Захирагч дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Зөвлөлд өргөн мэдүүлнэ”, 34.2.1 дэх заалтад “Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон” гэж заасны дагуу орон нутгийн төсвийн нийт орлогыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 104,300.2 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт 7. Аймгийн орлогын бүрдүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Сангийн ямны хянасан дүн	2025 он	
		Анх батлагдсан	Тодотгол
Б	1	2	3
ИТХ-ын шийдвэрийн огноо, дугаар	2025 оны төсвийн тухай хууль 2024.12.12	Аймгийн ИТХ-ын 2024.12.16 -ны 19 дүгээр тогтоол	Аймгийн ИТХ-ын 2025.07.18 -ны 42 дугаар тогтоол
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН СУУРЬ ОРЛОГО	29,923.8	35,807.7	39,127.6
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	69,036.7	119,725.8	104,300.2
УРСГАЛ ОРЛОГО	29,883.8	35,607.7	38,827.6
Татварын орлого	28,683.8	31,773.3	33,984.9
Татварын бус орлого	1,200.0	3,834.5	4,842.7
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	40.0	200.0	300.0
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	39,112.9	83,918.1	65,172.6
ОН-ын хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	10,770.9	16,422.8	10,770.9
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	28,342.1	39,573.0	28,342.1
Сум дүүргээс аймаг нийслэлд авсан тэгшитгэл		8,859.3	10,907.3
Бусад тусламж /Сумдын дэмжлэг/		19,063.0	15,152.3
УРД ОНЫ ҮЛДЭГДЛЭЭС		9,313.5	8,399.7

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Урсгал орлогын талаар: Орон нутгийн 2025 оны төсөвт татварын орлого 33,984.9 сая, татварын бус орлого 4,842.7 сая, нийт 38,827.6 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтийн талаар: Орон нутгийн төсөвт 2025 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого 10,770.9 сая, Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 28,342.1 сая, Сум дүүргээс аймаг нийслэлд авсан тэгшитгэл 10,907.3 сая, бусад тусламж 15,152.3 сая, нийт 65,172.6 сая төгрөгийн татаас санхүүжилт авахаар төлөвлөжээ.

Хөрөнгийн орлого: Хөрөнгийн орлогоос 300.0 сая төгрөг төвлөрүүлэхээр баталсан байна.

Урьд оны үлдэгдэл: Орон нутгийн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор 115,365.7 сая төгрөгөөр баталснаас тайлант оны орон нутгийн төсвийн орлого 104,300.2 сая, урд оны үлдэгдэл, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 11,065.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр байна.

Орон нутгийн төсвийн орлогыг аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 104,300.2 сая төгрөгөөр тодотгон баталсныг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр

/сая.төг/

№	Үзүүлэлт	2025 оны батлагдсан төсөв
	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	104,300.2
	НИЙТ ОРЛОГО	39,127.6
A	УРСГАЛ ОРЛОГО	38,827.6
1	Татварын орлого	33,985.0
1.1	Орлогын албан татвар	25,069.3
1.1.1	Хувь хүний орлогын албан татвар	26,686.0
1.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,616.7)
1.2	Өмчийн татвар	1,746.0
1.3	Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	1,135.0
1.3.1	Тусгай зориулалтын орлого	0.0
1.3.2	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,135.0
1.4	Бусад татвар /төлбөр хураамж/	6,034.7
2	Татварын бус орлого	4,842.7
Б	ХӨРӨНГИЙН ОРЛОГО	300.0
Б-1	Хөрөнгө борлуулсны орлого	300.0
В	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	65,172.5
В-1	ОН-ын хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	10,770.9
В-2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	28,342.1
В-3	Сум дүүргээс аймаг нийслэлд авсан тэгшитгэл	10,907.3
В-4	ТЗШ-ээр санхүүжих байгууллагын өөрийн орлого	0.0
В-5	ЭМД санхүүжих	0.0
В-6	Бусад тусламж /Сумдын дэмжлэг/	15,152.3

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Орон нутгийн төсвийн суурь орлогын 86.8 хувийг татварын орлогоос, 12.4 хувийг татварын бус орлогоос, 0.8 хувийг хөрөнгийн орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.



График 1. Суурь орлогын бүрдүүлэлт /сая.төг/

Татварын орлогын 73.8 хувийг Хувь хүний орлогын албан татвараас бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.




График 2. Татварын орлогын эзлэх хувь

2.2. Увс аймгийн 2025 оны нэгдсэн төсвийн зарлагыг өмнөх оны суурь үзүүлэлтэд тулгуурлан төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолуудаар төсвийн нийт зарлагыг 128,646.7 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын тогтоолуудаар 115,365.7 сая төгрөг болгон тодотгон баталсан байна.

Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/9591 дүгээр “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах, батлагдсан төсвийн хэрэгжилтийг зохион байгуулахад анхаарч ажиллах чиглэл”, Сангийн яамнаас хянасан суурь төсвийн зарлагыг үндэслэн орон нутгийн төсвийн зарлагыг анх төлөвлөсөн байна.

Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуульд УИХ-аас тодотгол хийсний дагуу орон нутгийн төсөвт тодотгол хийсэн байна.

Хүснэгт 9. Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он	
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв
Б	1	2	3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,469.4	128,646.7	115,365.7
УРСГАЛ ЗАРДАЛ	55,907.1	100,262.3	92,330.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,594.0	70,653.9	63,945.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,510.6	28,153.5	26,693.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,695.0	3,414.7	3,326.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,963.9	21,681.7	17,094.5
Хангамж, бараа материалын зардал	1,429.5	1,368.9	1,423.2
Нормативд зардал	313.5	711.7	448.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,242.6	1,941.4	2,258.4
Томилолт, зочны зардал	565.2	645.7	635.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,776.4	4,427.7	4,384.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,097.4	8,308.6	7,680.3
ТАТААС	53.8	153.7	141.7
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	53.8	153.7	141.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,259.2	29,454.7	28,243.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	27,922.2	26,775.6
Бусад урсгал шилжүүлэг	2,259.2	1,532.5	1,468.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,019.3	25,878.5	20,506.7

ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	543.0	2,505.9	2,528.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,664.1	128,646.7	115,365.7
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,546.3	16,422.8	10,770.9
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	0.0		
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	12,546.3	16,422.8	10,770.9
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,127.7	105,545.9	91,617.4
Орон нутгийн төсвөөс	61,127.7	105,545.9	91,617.4
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,990.1	6,678.0	12,977.4
ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0		
БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0		

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 4,182.6 сая төгрөгөөр өссөн нь Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал өмнөх оноос 1,130.6 сая төгрөгөөр өссөн нь шинээр баригдсан барилга байгууламж нэмэгдсэн, дулааны үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой байр ашиглалтын тогтмол зардлыг орон нутгийн төсөвт нэмж тусгаснаас шалтгаалжээ.

Бараа, ажил үйлчилгээний зардлын 41.8 хувийг цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, 5.2 хувийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 26.7 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 2.2 хувийг хангамж, бараа материалын зардал, 0.7 хувийг норматив зардал, 3.5 хувийг эд хогшил, урсгал засварын зардал, 1.0 хувийг томилолт, зочны зардал, 6.9 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, 12 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар төлөвлөсөн байна.



График 3. Бараа үйлчилгээний зардлыг нэр төрөл/ сая.төг/

Нийт зардал, цэвэр зээлийн дүнгийн 80.0 хувь нь урсгал зардал, 17.8 хувь нь хөрөнгийн зардал, 2.2 хувь нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байхаар төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 3 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН 100.9 ХУВИЙН БИЕЛЭЛТТЭЙ БАЙНА.

3.1. Орон нутгийн 2025 оны төсвийн татварын орлогын төлөвлөгөөг 2,217.9 сая төгрөгөөр буюу 106.5 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн 2025 оны төсвийн нийт орлого ба тусламжийн дүнг 104,300.2 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 105,196.5 сая төгрөг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 10. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он		Гүйцэтгэл	Зөрүү
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв		
Б	1	2	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	81,151.6	119,725.8	104,300.2	105,196.5	896.3
НИЙТ ОРЛОГО	37,728.3	35,807.7	39,127.6	40,114.2	986.6
УРСГАЛ ОРЛОГО	37,472.2	35,607.7	38,827.6	39,958.6	1,131.0
Татварын орлого	33,054.9	31,773.3	33,985.0	36,202.9	2,217.9
Орлогын албан татвар	25,897.5	24,130.8	25,069.3	26,506.5	1,437.2
Хувь хүний орлогын албан татвар	27,037.5	25,780.8	26,686.0	28,123.2	1,437.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(1,140.0)	(1,650.0)	(1,616.7)	(1,616.7)	0.0
Өмчийн татвар	1,378.8	1,521.7	1,746.0	1,757.2	11.2
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	970.1	985.0	1,135.0	1,150.1	15.1
Тусгай зориулалтын орлого	-	-	-	-	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	970.1	985.0	1,135.0	1,150.1	15.1
Бусад татвар /төлбөр хураамж/	4,808.5	5,135.8	6,034.7	6,789.1	754.4
Татварын бус орлого	4,417.3	3,834.4	4,842.7	3,755.7	(1,087.0)
ХӨРӨНГИЙН ОРЛОГО	256.1	200.0	300.0	155.6	(144.4)
Хөрөнгө борлуулсны орлого	256.1	200.0	300.0	155.6	(144.4)
ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	43,423.3	83,918.1	65,172.6	65,082.3	(90.3)
ОН-ын хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	12,546.3	16,422.8	10,770.9	10,680.6	(90.3)
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	30,877.0	39,573.0	28,342.1	28,342.1	0.0
Сум дүүргээс аймаг нийслэлд авсан тэгшитгэл	-	8,859.3	10,907.3	10,907.3	0.0
Бусад тусламж /Сумдын дэмжлэг/	-	19,063.0	15,152.3	15,152.3	0.0

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтийг 10,770.9 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг

28,342.1 сая, сум дүүргээс аймаг нийслэлд авсан тэгшитгэлийг 10,907.3 сая, бусад тусламж /сумдын дэмжлэг/-ийг 15,152.3 сая, нийт 65,172.6 сая төгрөгийн тусламжийн орлогыг баталж, гүйцэтгэлээр 65,082.3 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлэх санхүүжилтийн орлогыг төлөвлөснөөс 90.3 сая төгрөгөөр дутуу олгосон байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн суурь орлогыг татварын орлогоос 33,985.0 сая, татварын бус орлогоос 4,842.7 сая, хөрөнгийн орлогоос 300.0 сая, нийт 39,127.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр татварын орлого 36,202.9 сая, татварын бус орлого 3,755.7 сая, хөрөнгийн орлого 155.6 сая, нийт 40,114.2 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 102.5 хувиар биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн татварын орлогыг 33,985.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 36,202.9 сая төгрөгийн орлого төвлөрч, төлөвлөгөөг 2,217.9 сая төгрөгөөр буюу 106.5 хувиар биелүүлсэн байна. Орон нутгийн татварын орлого төлөвлөснөөс давж биелэхэд Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор хувь хүний орлогын албан татварын орлого нэмэгдсэн нь голчлон нөлөөлжээ.

Татварын орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг графикаар харуулбал дараах байдалтай байна.



График 4. Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Өмчийн татварын орлого 11.2 сая, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 754.4 сая, хувь хүний орлогын албан татвар 1,437.2 сая, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар 15.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт "Аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хотын төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.6.10 дахь заалтад "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь" гэж заасны дагуу Сангийн яамнаас Увс аймагт 2025 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 1,600.0 сая төгрөг хуваарилахаар анх баталж, тодотголоор 2,000.0 сая төгрөг болгон баталж ирүүлсэн байна. Сангийн яамны

ирүүлсэн суурь тоонд үндэслэн аймгийн ИТХ-аар төсөв батлахдаа 2025 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас 1,570.0 сая төгрөг оруулахаар баталж, тодотголоор 2,186.0 сая төгрөг болгон баталсан байна.

Ингэхдээ Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03/9591 дүгээр албан бичгийн 1-р хавсралтаар ирүүлсэн “Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийн 1.1.3-д “Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4.1-т аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 60 хувь нь улсын төсвийн орлого байхаар, мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10-т аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувь нь орон нутгийн төсвийн орлого байхаар тус тус заасан. Иймд УИХ-аар баталсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогын дүнг нэмэгдүүлэхгүй байх” гэж заасныг зөрчин аймгийн ИТХ-ын 2025 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийхдээ Сангийн яамнаас ирүүлсэн Увс аймгийн төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогын хэмжээг 2,000.0 сая төгрөг байсныг 2,186.0 сая төгрөг болгон 186.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Цаашид Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийг мөрдөж ажиллах зөвлөмж өглөө.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас орон нутгийн төсөвт 2,100.9 сая төгрөгийн орлого орж 96.1 хувийн биелэлттэй буюу төлөвлөгөөнөөс 85.1 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын бус орлогыг 4,842.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,755.7 сая төгрөгийн орлого төвлөрч 1,087.0 сая төгрөгөөр буюу 22.4 хувиар орлого тасарсан байна.

Хөрөнгө борлуулсны орлогыг 300.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 155.6 сая төгрөгийн орлого төвлөрч, 144.4 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 20/08 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өөрийн өмчийг түрээслүүлэх журам”-аар хөрөнгийн түрээсийн орлогын 40 хувь нь Орон нутгийн өмчийн сангийн дансанд, 60 хувь нь хөрөнгө эзэмшигч байгууллагын дансанд төвлөрдөг, мөн аймгийн ИТХ-ын 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 07/10 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-аар худалдаалсан хөрөнгийн орлогын 70 хувь нь Орон нутгийн өмчийн сангийн дансанд, 30 хувь нь хөрөнгө эзэмшигч байгууллагын дансанд төвлөрдөг зохицуулалт болон 2025 онд орон нутгийн худалдан борлуулахаар төлөвлөсөн зарим хөрөнгө зарагдаагүйгээс шалтгаалжээ.

3.2. Орлогын бүх гүйлгээ тухайн төсөв захирагчийн төрийн сангийн дансаар дамжин хийгдсэн байна.

Төсвийн тухай хууль, Төрийн сангийн үйл ажиллагааны журам, Төсвийн байгууллагад мөрдөх мөнгөн кассын ажиллагааны журмын дагуу Төсвийн байгууллагуудын болон төсөл хөтөлбөр, сангийн орлого, зарлагын гүйлгээ нь Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжин хийгдсэн байна.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.6.1-т "Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно", 3.6.2-т "Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна" гэж заасны дагуу 2025 онд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 12.9 сая, аймгийн Засаг даргын тамгын газар 530.8 сая төгрөгийг арилжааны банканд байрших кассын дансаар дамжуулан орлого, зарлагын гүйлгээ хийсэн байна.

Харин Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр албан бичгээр Төсвийн ерөнхийлөн захирагч нарт ирүүлсэн "Хамтран ажиллах тухай чиглэл"-ийн 3-д "Төсвийн байгууллагын төлбөр тооцоог цахимаар гүйцэтгэж байгаа тул байгууллагын цалин, жижиг мөнгөн сангийн данснуудыг хааж, хаасан тухай мэдээлэл ирүүлэх", 4-д "Арилжааны банкин дахь зөвшөөрөлгүй данснуудыг хааж, хаасан тухай мэдээллийг ирүүлэх" гэж заасны дагуу бусад төсвийн байгууллагуудын арилжааны банкин дахь дансыг хаалгасан байна.

Үүнээс шалтгаалан Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд хамрагдсан төсвийн шууд захирагчдын тайланд хийсэн аудитаар төсвийн байгууллагууд нярвын болон хувь хүний дансаар дамжуулан бэлэн мөнгө гаргаж зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.

Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам" болон Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/9469 дүгээр бичгээр ирүүлсэн чиглэл хоорондоо нийцэхгүй байгаа асуудлыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэл тайлангийн дараагийн аудитаар анхаарах асуудал хэсэгт тусгасан болно.

**БҮЛЭГ 4 ОРОН НУТГИЙН НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ
ТӨЛӨВЛӨСНӨӨС 7,238.3 САЯ ТӨГРӨГӨӨР ХЭМНЭГДСЭН БАЙНА.**

**4.1. Орон нутгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс
7,238.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.**

Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 47 төсвийн шууд захирагч, 19 төвлөрүүлэн захирагч, 8 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 41 тусгай сан, нийт 115 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 52 тайланд дүгнэлт гаргаж, 63 тайланг түүвэрт хамруулсан. Үүнээс 46 санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй”, 6 санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн.

Түүнчлэн улсын төсвийн 106 байгууллагын санхүүгийн тайлан байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, урсгал засварын зардлын хувьд нэгтгэлд хамрагдсан байна.

Орон нутгийн 2025 оны нэгдсэн төсвийн зарлагыг 115,365.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 108,127.4 сая төгрөгийг зарцуулж, 7,238.3 сая төгрөгийг хэмнэсэн байна. Тайлант оны нийт зарлагын гүйцэтгэл нь өмнөх оноос 33,658.0 сая төгрөгөөр буюу 45.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 11. Аймгийн ТЕЗ-ийн хөтөлбөрөөр бэлтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /сая.төг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он			Зөрүү
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	
А	Б	1	2	3	4	5=4-3
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,469.4	128,646.7	115,365.7	108,127.4	(7,238.3)
2	УРСГАЛ ЗАРДАЛ	55,907.1	100,262.3	92,330.9	89,401.5	(2,929.4)
3	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	53,594.0	70,653.9	63,945.4	61,331.9	(2,613.6)
4	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,510.6	28,153.5	26,693.2	26,361.7	(331.5)
5	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,695.0	3,414.7	3,326.6	3,256.8	(69.9)
6	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,963.9	21,681.8	17,094.5	16,432.5	(662.0)
7	Хангамж, бараа материалын зардал	1,429.5	1,368.9	1,423.2	1,114.1	(309.1)
8	Нормативд зардал	313.5	711.7	448.4	439.3	(9.2)
9	Эд хогшил, урсгал засварын зардал	1,242.6	1,941.4	2,258.4	2,116.7	(141.7)
10	Томилолт, зочны зардал	565.2	645.7	635.7	549.8	(85.9)
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,776.4	4,427.7	4,384.9	4,203.4	(181.6)
12	Бараа үйлчилгээний бусад зардал	5,097.4	8,308.6	7,680.3	6,857.6	(822.7)
13	ТАТААС	53.8	153.7	141.7	130.8	(11.0)
14	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	53.8	153.7	141.7	130.8	(11.0)
15	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,259.2	29,454.7	28,243.8	27,938.9	(304.9)
16	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	27,922.3	26,775.6	26,751.0	(24.6)
17	Бусад урсгал шилжүүлэг	2,259.2	1,532.5	1,468.1	1,187.9	(280.3)

18	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,019.3	25,878.5	20,506.7	18,078.8	(2,428.0)
19	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	543.0	2,505.9	2,528.0	647.1	(1,881.0)

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Нийт зардал, цэвэр зээлийн дүнгийн 80 хувь нь урсгал зардал, 17.8 хувь нь хөрөнгийн зардал, 2.2 хувь нь эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл байхаар төлөвлөсөн байна.

Цалин хөлс ба нэмэгдэл урамшууллын зардал 331.5 сая төгрөг буюу 1.2 хувиар, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 69.9 сая төгрөг буюу 2.1 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 662.0 сая төгрөг буюу 3.9 хувиар, хангамж бараа материалын зардал 309.1 сая төгрөг буюу 21.7 хувиар, норматив зардал 9.2 сая төгрөг буюу 2 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 141.7 сая төгрөг буюу 6.3 хувиар, томилолт зочны зардал 85.9 сая төгрөг буюу 13.5 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 181.6 сая төгрөг буюу 4.1 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 822.7 сая төгрөг буюу 10.7 хувиар тус тус хэмнэгдсэн байна.

Хүснэгт 12. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний төсвийн зарцуулалт

/сая.төг/

№	Хөтөлбөрийн нэр	Хөтөлбөрийн ангилал	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	Хувь
1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	70105	6,103.2	5,696.1	407.0	93.3%
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	70106	72,733.6	69,034.6	3,699.0	94.9%
3	Худалдан авах ажиллагаа	70418	482.5	464.4	18.1	96.2%
4	Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	70426	513.1	467.1	46.1	91.0%
5	Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	70429	494.1	475.6	18.5	96.3%
6	Доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлого	70504	10,907.3	10,907.3	-	100.0%
7	Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх	70708	600.0	573.2	26.8	95.5%
8	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	70709	245.5	192.5	53.0	78.4%
9	Мал аж ахуйг хөгжүүлэх	70801	1,055.9	1,055.9	-	100.0%
10	Авто зам	71101	1,188.9	1,159.2	29.7	97.5%
11	Ойжуулалт	71403	438.9	404.9	34.0	92.2%
12	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	71411	2,081.5	2,068.6	12.9	99.4%
13	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх	71413	597.6	437.1	160.5	73.1%
14	Хот байгуулалт, тохижилт	71502	-	-	-	-
15	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	71602	2,419.5	2,345.6	73.9	96.9%
16	Биеийн тамир спорт	71701	674.3	674.3	0.0	100.0%
17	Соёл урлаг	71702	1,842.9	1,466.4	376.5	79.6%
18	Сургуулийн өмнөх боловсрол	71801	2,181.6	2,083.5	98.1	95.5%
19	Ерөнхий боловсрол	71802	6,791.1	6,687.0	104.1	98.5%
20	Мэргэжлийн боловсрол	71804	662.0	661.8	0.1	100.0%
21	Нийгмийн халамж	71902	491.4	330.5	160.9	67.3%
22	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	72101	2,574.3	661.4	1,912.9	25.7%

23	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгаалал	72206	40.6	40.6	-	100.0%
24	Ахмад настны хөгжил хамгаалал	72208	115.2	109.2	6.1	94.7%
25	Гэр бүлийн хөгжил, хамгаалал	72212	130.6	130.6	-	100.0%
Нийт дүн			115,365.7	108,127.4	7,238.3	93.7%

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 115,365.7 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 108,127.4 сая төгрөг зарцуулсанд дараах хүчин зүйлс голлон нөлөөлсөн байна. Үүнд:

- Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт төлөвлөсөн хэмжээнд хүрээгүйгээс хөрөнгийн эх үүсвэр хангалтгүй бүрдсэн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд орон нутгийн төсөвт байгууллагууд хэмнэлт гарган ажилласан,
- ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг гүйцэтгэлд нь үндэслэн санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Хүснэгт 13. Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он			
			Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
А	Б	1	2	3	4	5=4-3
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	75,664.1	128,646.7	115,365.7	108,127.4	(7,238.3)
2	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,546.3	16,422.7	10,770.9	10,680.6	(90.3)
3	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	12,546.3	16,422.7	10,770.9	10,680.6	(90.3)
4	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	61,127.7	105,545.9	91,617.4	95,655.2	4,037.7
5	Орон нутгийн төсвөөс	61,127.7	105,545.9	91,617.4	95,655.2	4,037.7
6	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,990.1	6,678.0	12,977.4	1,791.6	(11,185.8)
7	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0	0.0
8	БУСАД ЭХ ҮҮСВЭР	0.0	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Зардлыг санхүүжүүлэх 108,127.4 сая төгрөгийн эх үүсвэрийг гүйцэтгэлээр авч үзвэл улсын төсвөөс 10,680.6 сая төгрөг буюу 9.9 хувийг, орон нутгийн төсвөөс 95,655.2 сая төгрөг буюу 88.4 хувийг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 1,791.6 сая төгрөг буюу 1.7 хувийг тус тус санхүүжүүлсэн байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгдсэн тайланд нэгтгэгдсэн төсөвт байгууллага, аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар төсөв, хөрөнгийн зарцуулалттай холбоотойгоор 2,636.4 сая төгрөгийн 40 зөрчил илрүүлснээс 12.5 сая төгрөгийн 6 төлбөрийн акт, зөрчлийг давтан гаргахгүй байх, таслан зогсоох 87.7 сая төгрөгийн 14 албан шаардлага, 2,536.2 сая төгрөгийн 20 зөвлөмж өгсөн.

Орон нутгийн хөгжлийн сан:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд улсын төсвөөс Увс аймагт олгох орлогын шилжүүлгийг 16,422.8 сая төгрөгөөр баталсан ба Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 10,770.9 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг олгохоор хуульчилсан байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 7,547.9 сая, сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 10,188.5 сая төгрөгөөр баталж, 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн олгох орлогын шилжүүлгийг 6,547.9 сая, сумдад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 5,546.6 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт 14. Аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээ

/сая.төг/

Аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээ				
№	Нэр	Анх баталсан	Тодотгон баталсан	Зөрүү
1	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	7,547.9	6,547.9	1,000.0
2	Баруунтуруун сум	289.9	110.9	179.0
3	Бөхмөрөн сум	869.4	439.4	430.0
4	Давст сум	373.4	273.4	100.0
5	Завхан сум	510.4	140.4	370.0
6	Зүүнговь сум	332.8	285.8	47.0
7	Зүүнхангай сум	219.4	124.4	95.0
8	Малчин сум	352.2	302.2	50.0
9	Наранбулаг сум	1,942.8	447.8	1,495.0
10	Өлгий сум	230.8	200.8	30.0
11	Өмнөговь сум	369.8	296.3	73.5
12	Өндөрхангай сум	384.2	171.8	212.4
13	Сагил сум	288.3	208.3	80.0
14	Тариалан сум	779.3	479.3	300.0
15	Түргэн сум	543.1	369.8	173.3
16	Тэс сум	328.6	208.6	120.0
17	Ховд сум	316.4	116.4	200.0
18	Хяргас сум	425.0	247.4	177.6
19	Цагаанхайрхан сум	420.7	103.0	317.6
20	Улаангом сум	1,212.0	1,020.5	191.5
	Сумдад хуваарилсан дүн	10,188.5	5,546.6	4,641.9
	Нийт дүн	17,736.4	12,094.5	5,641.9

Эх сурвалж: Увс аймгийн ИТХ-ын тогтоол

Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор ОНХС-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын эх үүсвэрийг 12,094.5 сая төгрөгөөр баталсан нь анх баталснаас 5,641.9 сая төгрөгөөр бууруулсан байна. Энэ нь ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 5,651.9 сая төгрөгөөр бууруулан тодотгол хийсэнтэй холбоотой байна.

Улаангом сумын 5-р багийн автозамын зураг төсөв шинэчлэх 50.0 сая, Зураг төсөв, геологийн судалгааны зардал 18.9 сая, нийт 68.9 сая төгрөгийг 2024 оны 11 сард ОНХС-ийн үлдэгдлээс барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлж зардлаар бүртгэсэн байна.

Гэтэл аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийн урьд оны дансны үлдэгдэл 1,244.7 сая төгрөг байхад аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолд 1,313.6 сая төгрөгөөр буюу дээрх 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт 68.9 сая төгрөгийг нэмж тусган батлуулсан байна. Уг зөрчилд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид болон аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар ОНХС-тай холбоотой нийт 272.1 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 15.8 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 256.3 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн аудитын илрүүлэлт:

- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж аймгийн Засаг даргын 2025 оны А/666 дугаар захирамжаар аймгийн ОНХС-аас 763.5 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрийг батлахдаа урьд оны дансны үлдэгдэл 1,244.7 сая төгрөг байхад 1,313.6 сая төгрөг буюу 68.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- "Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлд оруулах тухай" хуулиар ОНХС-аас Увс аймагт олгох орлогын шилжүүлгийг 10,770.9 сая төгрөг гэж баталсан байхад аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар аймгийн 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 10,780.9 сая төгрөгөөр буюу 10.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 6,547.9 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээний мэдээллийг Сангийн яамны ОНХС-ийн мэдээллийн <https://onhs.mof.gov.mn/> цахим системд мэдээлээгүй зөрчилд зөвлөмж өгсөн.

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- **Түргэн сумын ТТЗ:** Засаг даргын 2025 оны А/78 дугаар захирамжаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 06/01 дугаар тогтоолоор баталсан "Дэлгэрмөрөн самбартай хөтөлд үдэлт, угталтын талбайн засвар" төсөл, арга хэмжээнд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 5.0 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- **Өмнөговь сумын ТТЗ:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 6.9 сая төгрөгийн тэмцээн уралдаан, баярын зардлыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан санхүүжүүлсэн зөрчилд албан шаардлага өгсөн.

- **Ховд сумын ТТЗ:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 3.9 сая төгрөгийн цахилгаан эрчим хүчний төлбөр төлсөн зөрчилд албан шаардлага өгсөн.
- **Улаангом сумын ТТЗ:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 32.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өвс, тэжээлийн нөөц бэлтгэхдээ шууд худалдан авалт хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Өндөрхангай сумын ТТЗ:** Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 07/01 дугаар “Сумын 2025 оны тодотгосон төсөв батлах тухай” тогтоолоор батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Сумын төвийн тохижилтын 119.8 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Бэст Вүүдэн Хаус” ХХК, Сумын төвийн тохижилтын 68.0 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Ус-Инженеринг” ХХК, Сумын төвийн тохижилтын 74.5 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Болд тинкер” ХХК, Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар, тохижилтын 27.4 сая төгрөгийн гэрээний дүнтэй ажлыг “Болд тинкер” ХХК-аар тус тус гүйцэтгэхээр гэрээлсэн байна. Дээрх 4 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч компаниуд нь гэрээний хугацаандаа хийж дуусгаагүй зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Бөхмөрөн сумын ТТЗ:** Орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжих өвс, тэжээлийн нөөц бэлтгэх 137.3 сая төгрөгийг сумын болон багийн гэж 4 хуваан шууд худалдан авалт хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Малчин сумын ТТЗ:** Халуун усны байр засварлах болон тохижуулах 19.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 13.3 сая, Хүрэн морьтын давааны хөтлийн тохижилт 19.5 төгрөгийн өртөгтэй ажилд 16.6 сая, Ногоон байгууламжийн хашаа засварлах 3.0 сая төгрөгийн өртөгтэй ажилд 2.1 сая, нийт 9.4 сая төгрөгөөр дутуу буюу урьдчилгаа төлбөрийн дүнгээр нь гэрээ байгуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Наранбулаг сумын ТТЗ:** Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор батлагдсан ажлын жагсаалтад байхгүй Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтэд 13.0 сая төгрөгийг өмнөх онд иргэдэд зээлээр борлуулсан өвсний үнийн эргэн төлөлтөөс шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн зөрчилд зөвлөмж өгсөн
- **Наранбулаг сумын ТТЗ:** Сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 05/03 дугаар тогтоолоор Малын ангилан ялгалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зардалд 5.0 сая төгрөг баталсан байхад гүйцэтгэлээр 5.6 сая төгрөг буюу 0.6 сая төгрөг илүү зарцуулсан зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Сагил сумын ТТЗ:** Сумын Засаг даргын 2025 оны А/99 дүгээр захирамжаар сумын Орон нутгийн хөгжлийн сангаас 60.0 сая төгрөгийг сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн зөрчилд зөвлөмж өгсөн.
- **Хяргас сумын ТТЗ:** Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Малын үүлдэр угсааг сайжруулах” төсөл, арга хэмжээний хүрээнд 4.0 сая төгрөгөөр 40 ширхэг хурган хуц худалдан авсныг орлогод аваагүй зөрчилд зөвлөмж өгсөн.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор аймгийн ОНХС-ийн орлогыг 5,234.3 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 1,323.6 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, нийт 6,547.9 сая төгрөгөөр 13 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталж гүйцэтгэлээр 5,593.1 сая төгрөгийн зардал гарсан байна. Үүнд:

Хүснэгт 15. Аймгийн ОНХС-ийн хэрэгжээгүй төсөл арга хэмжээ, батлагдсан төсөв

/сая.төг/

№	Хөтөлбөр	Тайлант оны батлагдсан төсөв	Гүйцэтгэл
1	Эрүүл мэндийн салбарын хөтөлбөр, төсөл, арга хэмжээ	1,397.9	1,261.8
2	Тариалан сумын наадмын талбайн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	188.5

3	Түргэн сумын наадмын талбайн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	200.0
4	Малчин сумын төвийн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	197.6
5	Завхан сумын наадмын талбайн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	194.1
6	Давст сумын төвийн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	138.4
7	Сагил сумын төвийн тохижилтын ажилд дэмжлэг	200.0	199.6
8	Морь барианы газрын тохижилт	1,000.0	996.9
9	Улаангом сумын засвар, тохижилт	1,100.0	1,061.8
10	Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах, геологийн зардал	680.0	285.3
11	Төвлөрсөн хогийн цэгт машин механизм худалдан авах	750.0	749.3
12	Улаангом сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлыг эхлүүлэх	300.0	0.0
13	Гадаадын иргэн харьяатын газарт-автомашины парк шинэчлэлт	120.0	120.0
	Дүн	6,547.9	5,593.1

Эх сурвалж: Увс аймгийн ОНХС-ийн тайлан

ОНХС-ийн данснаас бүрэн хэрэгжиж дуусаагүй, хэрэгжиж эхлээгүй төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 763.5 сая төгрөгийг Засаг даргын 2025 оны А/666 дугаар захирамжаар барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн байна. Үүнд:

- Давст сумын төвийн тохижилтын ажилд дэмжлэг- 59.3 сая төгрөг,
- Зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах, геологийн зардал- 404.2 сая төгрөг,
- Улаангом сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлыг эхлүүлэх- 300.0 сая төгрөг

Аймгийн төсвийн тодотголоор нэмэгдсэн Улаангом сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлыг эхлүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан тул тайлант онд гүйцэтгэлээр санхүүжилт гараагүй байна.

Замын сан

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор Автозамын сангийн хөрөнгөөр 2025 онд 1,188.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр баталсан бөгөөд тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна.

Замын сангийн харилцах дансанд 1,188.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж 1,159.2 сая төгрөгийг зарцуулж, 29.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 16. Замын сангийн төсвийн гүйцэтгэл, үр дүн

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71101-Авто зам 82214-Орон нутгийн чанартай авто замын засвар үйлчилгээ	1,188.9	1,159.2	29.7	97.5%
	Нийт дүн	1,188.9	1,159.2	29.7	97.5%

Эх сурвалж: Увс аймгийн Замын сангийн 2025 оны санхүүгийн тайлан

Тайлант онд авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх 1,188.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл” төсөл, арга

хэмжээг 2 багц болгон худалдан авах ажиллагааг tender.gov.mn цахим хуудсанд байршуулан зохион байгуулсан байна. Үүнд:

- Багц-1 "Улаангом сумын авто замын засвар, шинэчлэлийн босоо тэмдэг суурилуулах" -136.9 сая төгрөг,
- Багц-2 "Улаангом сумын авто замын засвар, шинэчлэл"-1,029.7 сая төгрөг

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 1 төсөл, арга хэмжээнд 12.1 сая төгрөг батлагдсан бөгөөд тодотголоор өөрчлөлт оруулаагүй байна.

Хүснэгт 17. Байгаль хамгаалах сангийн төсвийн гүйцэтгэл, үр дүн

/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	2025 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөв	Гүйцэтгэл	Хувь
1	Усны эх үүсвэрийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	12.1	12.1	12.1	100
	Нийт дүн				

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 19 дүгээр "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" тогтоолоор аймгийн их засвар, хөрөнгө оруулалтын хүрээнд шинээр хэрэгжүүлэх 9, он дамжин хэрэгжих 2, нийт 11 төсөл, арга хэмжээнд 2025 онд 4,098.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор баталж, 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор шинээр хэрэгжүүлэх 13, он дамжин хэрэгжих 2, нийт 15 төсөл, арга хэмжээнд 2025 онд 4,053.3 сая төгрөгийн төгрөгийн санхүүжилтийг олгохоор тодотгон баталсан байна.

Дээрх Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн их засвар, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг "Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт гүйцэтгэлийн аудитад хамруулна.

Хөтөлбөр, төсөл, арга хэмжээ

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор 2025 оны төсвийн жилд 4,250.0 сая төгрөгийн 8 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2025 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 42 дугаар тогтоолоор 500.0 сая төгрөгийн 1 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хасаж, 3,750.0 сая төгрөгийн 7 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болгон тодотгон баталсан байна.

Дээрх Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг "Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт" сэдэвт гүйцэтгэлийн аудитад хамруулна.

Техник хяналт, барьцаа хөрөнгө оруулалтын данс

Барьцаа хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь 100150051030 тоот дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 6,798.9 сая төгрөг, тайлант хугацаанд

2,809.0 сая төгрөгийн орлого төвлөрч, 4,880.5 сая төгрөгийг зарцуулж, 4,727.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн ЗДТГ-ын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 6/2027 дугаар бичгээр их засвар хөрөнгө оруулалт, ОНХС, Засаг даргын ерөнхий данс, Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас хэрэгжих төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулах хүсэлт ирүүлсний дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/666 дугаар захирамжаар 7 төсөл, арга хэмжээний нийт 1,803.9 сая төгрөгийг байршуулах шийдвэр гарсан байна.

Хүснэгт 18. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан ОНТХО-аар хийгдэх төсөл, арга хэмжээний нэр, төсөвт өртөг

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эх үүсвэр	2025 оны эцэст байршуулсан
1	Өвс тэжээлийн нөөц бэлтгэх зардал	Засаг даргын ерөнхий данс	150.0
2	Галданбошигт хорооллын ус, дулаан дамжуулах төвийн БУА	Их засвар, хөрөнгө оруулалт	110.0
3	Тэс сумын дотуур байрны барилгын засвар, тохижилт	Их засвар, хөрөнгө оруулалт	80.4
4	Ю.Цэдэнбалын нэрэмжит музейн барилгын засвар	Аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс	700.0
5	Давст сумын төвийн тохижилтын ажилд дэмжлэг	ОНХС	59.3
6	Зураг төсөв, геологийн судалгааны зардал	ОНХС	404.2
7	УГ сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө хийлгэх ажлын эхлэл	ОНХС	300.0
8	Ю.Цэдэнбалын нэрэмжит талбайн засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл	Аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн данс	139.6
	ОНТХО-ын дүн		1,943.5

Эх сурвалж: Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн судалгаа

Дээрх хүснэгтэд тусгагдсан Ю.Цэдэнбалын нэрэмжит талбайн засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 139.6 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын даргын 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/180 дугаар тушаалаар барилгын барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Мөн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 8.1-д "ОНХС нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн санд данстай байх бөгөөд сангийн орлого, зарлагыг зөвхөн энэхүү дансаар дамжуулан гүйцэтгэнэ" гэж заасныг зөрчиж аймгийн Орон нутгийн хөгжлийн сангаас 763.5 сая төгрөгийг барилгын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлж "Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө" сэдэвт гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар албан шаардлага өгсөн.

Барилгын барьцаа хөрөнгийн дансны оны эхний үлдэгдлээс тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 3 төсөл, арга хэмжээний 2,177.8 сая, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээний 695.6 сая, нийт 9 төсөл, арга хэмжээний 2,873.4 сая төгрөгийн төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Техник хяналт зардлын Төрийн сан дахь 100150000370 тоот дансанд оны эхэнд үлдэгдэл 223.0 сая төгрөг, тайлант хугацаанд 232.7 сая төгрөг төвлөрч, 449.1 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 6.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн ерөнхий орлого

Орон нутгийн ерөнхий орлогын Төрийн сан дахь 100150000910 тоот дансны мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл 4,445.4 сая төгрөг, тайлант хугацаанд 46,203.5 сая төгрөгийн орлого төвлөрч, 45,314.3 сая төгрөгийг зарцуулж, 5,334.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

4.2. Бүтэц, орон тооны талаар:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.3 дахь заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэж заасны дагуу Төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгддэг 47 төсвийн байгууллага орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоосон байна.

Төлөвлөсөн орон тооноос дараах 4 байгууллага орон тоо дутуу ажилласан байна. Үүнд:

Хүснэгт 3. Орон тооны гүйцэтгэл дутуу байгууллагууд

№	Байгууллагын нэр	Удирдах		Гүйцэтгэх		Үйлчлэх		Гэрээт		Нийт	
		төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц	төл	гүйц
1	Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар	1	1	9	6	2	3	-	-	12	10
2	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	1	1	7	6	2	2	-	-	10	9
3	Аймгийн Засаг даргын тамгын газар	11	10	48	58	50	40	-	-	109	108
4	Улаангом сумын Засаг даргын тамгын газар	15	15	31	30	8	8	16	16	70	69
Дүн										201	196

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 онд Увс аймгийн Худалдан авах ажиллагааны газар-2, Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба-1, аймгийн Засаг даргын тамгын газар-1, Улаангом сумын Засаг даргын тамгын газар-1 орон тоогоор тус тус дутуу ажилласан байна.

Засгийн газрын 2009 оны “Сумын Засаг даргын тамгын газрын орон тооны хязгаарыг тогтоох тухай” 13 дугаар тогтоолоор сумын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг 1501-3000 хүртэл хүн амтай суманд 15, 3001-5000 хүртэл хүн амтай суманд 16, 5001-10000 хүртэл хүн амтай суманд 18 байхаар тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжаар 18 сумдын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна. Ингэхдээ 5 сумын ЗДТГ-ыг 17 орон тоогоор, 9 сумын ЗДТГ-ыг 18 орон тоогоор, 4 сумын ЗДТГ-ыг 19 орон тоотойгоор баталжээ.

Үүнд улс төрийн албан хаагч буюу сумын Засаг дарга, Засаг даргын орлогч гэсэн 2 орон тоог нэмж баталсан байна.

Мөн Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 376 дугаар “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын

иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг тогтоох тухай” тогтоолын 1-д “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 8, Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 12 хүртэл орон тоотой байхаар тус тус тогтоосугай” гэж заасан байна. Гэтэл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлахдаа 15 орон тоотойгоор баталсан байна.

Дээрх орон тоонд ИТХ-ын дарга, хурлын даргын туслах, хэвлэл мэдээллийн ажилтан гэсэн 3 орон тоог нэмж баталжээ.

Дээрх 2 асуудлыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дараагийн аудитаар анхаарах асуудлын хэсэгт тусгасан.

Харин Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/16 дугаар захирамжаар баталсан бүтэц орон тоонд байхгүй дараах орон тоог тухайн сумдын Засаг даргын тамгын газар нь бүтэц орон тоондоо нэмж батлан ажиллуулж байна. Үүнд:

№	Байгууллагын нэр	Сантехникч	Олон нийтийн цагдаа	Багийн сахиул	Манаач, сахиул	Үйлчлэгч	Жижүүр	Нийт
1	Баруунтуруун сумын ЗДТГ	1	1	2				4
2	Бөхмөрөн сумын ЗДТГ	1	1	2	1			5
3	Давст сумын ЗДТГ	1	1	2	1			5
4	Завхан сумын ЗДТГ	1	1	3				5
5	Зүүнговь сумын ЗДТГ	1	1	3				5
6	Зүүнхангай сумын ЗДТГ	1		4	1			6
7	Малчин сумын ЗДТГ	1	1	3				5
8	Наранбулаг сумын ЗДТГ		1	4	1	1		7
9	Өлгий сумын ЗДТГ	1	1	3		1		6
10	Өмнөговь сумын ЗДТГ	1		4	1			6
11	Өндөрхангай сумын ЗДТГ	1	1	4				6
12	Сагил сумын ЗДТГ	1		5				6
13	Тариалан сумын ЗДТГ	1	1	4	1			7
14	Түргэн сумын ЗДТГ	1	1	2	1			5
15	Тэс сумын ЗДТГ	1	1	2	1		2	7
16	Ховд сумын ЗДТГ	1		3	1			5

17	Хяргас сумын ЗДТГ	1	1	3	1			6
18	Цагаанхайрхан сумын ЗДТГ	1	1	3				5
Нийт дүн								101

Эх сурвалж: Сумдын ЗДТГ-ын бүтэц орон тоо баталсан шийдвэр

Энэ асуудлыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дараагийн аудитаар анхаарах асуудлын хэсэгт тусгасан болно.

Бүтэц орон тоотой холбоотой зөрчилд төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар Аймгийн ИТХ-д 1 зөвлөмж, Улаангом сумын Засаг даргын Тамгын газарт 1 албан шаардлага өгсөн байна. Үүнд:

- **Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:** Байгууллагын батлагдсан бүтэц, орон тоонд байхгүй нярвын ажлыг хавсруулж 5,104.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон зөвлөмж өгсөн.
- **Увс аймгийн Улаангом сумын Засаг даргын Тамгын газар:** Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн батлагдсан орон тоонд байхгүй албан тушаалыг хавсруулахгүй байх зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүйд албан шаардлага өгсөн.

**БҮЛЭГ 5 ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ
(2,930.9) САЯ ТӨГРӨГ БАЙНА.**

5.1. Нэгдсэн төсвийн нийт тэнцэл (2,930.9) сая төгрөг байна.

Увс аймгийн 2025 оны төсвийн урсгал тэнцлийг (53,503.3) сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр (49,442.9) сая төгрөг байна.

Хүснэгт 20. Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүн гүйцэтгэл

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он			
		Анх батлагдсан	Тодотгосон төсөө	Гүйцэтгэл	Зөрүү
А	1	2	3	4	5=4-3
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	81,151.6	119,725.8	104,300.2	105,196.5	896.3
А.УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	37,472.2	35,607.7	38,827.6	39,958.6	1,131.0
1.Татварын орлого	33,054.9	31,773.3	33,985.0	36,202.9	2,217.9
2.Татварын бус орлого	4,417.3	3,834.4	4,842.7	3,755.7	- 1,087.0
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	256.1	200.0	300.0	155.6	- 144.4
В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	43,423.3	83,918.1	65,172.5	65,082.3	- 90.3
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	74,469.4	128,646.8	115,365.7	108,127.4	- 7,238.3
А.УРСГАЛ ЗАРЛАГА	55,907.1	100,262.3	92,330.9	89,401.5	- 2,929.4
1.Бараа, үйлчилгээний зардал	53,594.0	70,653.9	63,945.4	61,331.8	- 2,613.6
1.1. Цалин, хөлс	22,510.6	28,153.5	26,693.2	26,361.7	- 331.5
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл	2,695.0	3,414.7	3,326.6	3,256.7	- 69.9
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	28,388.4	39,085.7	33,925.5	31,713.4	- 2,212.1
3.Татаас ба урсгал шилжүүлэг	2,313.0	29,608.4	28,385.5	28,069.7	- 315.8
3.1. Татаас	53.8	153.7	141.7	130.8	- 10.9
3.2. Урсгал шилжүүлэг	2,259.2	29,454.7	28,243.8	27,938.9	- 304.9
Б.ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	18,019.3	25,878.6	20,506.7	18,078.8	- 2,427.9
В.ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	543.0	2,505.9	2,528.0	647.1	- 1,880.9
1.Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	543.0	2,505.9	2,528.0	647.1	- 1,880.9
УРСГАЛ ТЭНЦЭЛ	-18,434.9	-64,654.6	-53,503.3	-49,442.9	4,060.4
НИЙТ ТЭНЦЭЛ	6,682.2	-8,920.9	-11,065.5	-2,930.9	8,134.6
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР					
1. Мөнгөн хөрөнгийн цэвэр еөрчлөлт	6,682.2			-2,930.9	
2. Өмнөх оны үлдэгдлээс санхүүжих		9,313.5	8,399.7		

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Орон нутгийн нэгдсэн төсвийн үр дүнгийн орлогын гүйцэтгэл 105,196.5 сая, зардлын гүйцэтгэл 108,127.4 сая буюу тайлант оны нийт тэнцэл -2,930.9 сая төгрөг байна.

5.2. Орон нутгаас баталсан Халамжийн сангийн төсөв 160.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Орон нутгийн төсвөөс Халамжийн санд 491.4 сая төгрөг зарцуулахаар батлагдсанаас 330.5 сая төгрөгийг 2 нэр төрлийн халамжийн үйлчилгээнд зарцуулж, хэмнэгдсэн үлдэгдэл 160.9 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 21. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн Халамжийн сангийн гүйцэтгэл

/сая.төг/

№	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Онцгой тохиолдлын тэтгэмж	70.1	69.6	-0.5
2	Олон нийтийн оролцоон түшиглэсэн халамжийн үйлчилгээ	421.3	260.9	-160.4
	Нийт дүн	491.4	330.5	-160.9

Эх сурвалж: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын судалгаа

Онцгой тохиолдлын тэтгэмжийг 1 иргэнд 1.2 сая төгрөгөөр тооцож нийт 58 иргэнд олгосон бөгөөд батлагдсан санхүүжилтийн зөрүү 0.5 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 2025 онд хамрагдсан иргэдийн мөнгийг бүрэн олгосон бөгөөд батлагдсан санхүүжилтийн зөрүү 160.4 сая төгрөг хэмнэгдсэн байна.

5.3. Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөө 2,662.7 сая төгрөгөөр тасарсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого:

Нийгмийн даатгалын санд 57,564.8 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 54,902.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, төлөвлөгөө 2,662.7 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар тасарсан байна.

Хүснэгт 22. Нийгмийн даатгалын сангийн орлогын гүйцэтгэл

/сая.төг/

№	Нийгмийн даатгалын сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /-илүү, +дутуу/
1	Тэтгэврийн даатгал	50,058.0	46,354.7	-3,703.3
2	Тэтгэмжийн даатгал	4,181.5	4,757.8	576.3
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	1,856.3	2,183.2	326.9
4	Ажилгүйдлийн даатгал	1,469.0	1,606.4	137.4
	Нийт дүн	57,564.8	54,902.1	2,662.7

Эх сурвалж: Нийгмийн даатгалын газрын судалгаа

Нийгмийн даатгалын сангийн орлого 2,662.7 сая төгрөгөөр тасрахад тэтгэврийн даатгалын сангийн орлого 3,703.3 сая төгрөгөөр тасарсан нь гол нөлөөг үзүүлжээ. Үүнд: Төрийн зарим албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор ажил олгогчоос төлөх шимтгэлийн орлого 1,280.0 сая,

даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлого 200.0 сая төгрөгөөр давж биелсэн ч, сайн дурын даатгалын орлого 4,440.0 сая, малчдын нөхөн даатгал хэрэгжээгүйгээс 806.6 сая төгрөгөөр тус тус орлого тасарсан нь нөлөөлжээ.

Түүнчлэн Статистикийн албан мэдээгээр 2025 онд Монгол улсын инфляц 6.5 хувь, ДНБ-ийн бодит өсөлт 6.6-6.8 хувь, эдийн засгийн өсөлт уул уурхайгаас голлон хамаарч байсан. Увс аймгийн хувьд хөдөө аж ахуйн салбараас ихээхэн хамааралтай бөгөөд 2025 он гантай байсан, түүхий эдийн үнэ буурсан зэргээс шалтгаалан өрхийн сарын дундаж орлого 1.8-1.9 сая төгрөг болсон нь сайн дурын даатгалын орлого бууруулахад нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага:

Тайлант онд нийгмийн даатгалын сангийн нэр төрөл бүрээр нийт 137,072.4 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 136,562.8 сая төгрөг зарцуулж, төлөвлөснөөс 509.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Хүснэгт 43. Нийгмийн даатгалын сангийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

№	Нийгмийн даатгалын сангийн зарлагын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /-илүү, +дутуу/
1	Тэтгэврийн даатгал	127,660.8	127,131.2	-529.6
2	Тэтгэмжийн даатгал	6,853.7	6,988.9	135.2
3	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал	312.0	208.8	-103.2
4	Ажилгүйдлийн даатгал	2,245.9	2,233.9	-12.0
Нийт дүн		137,072.4	136,562.8	-509.6

Эх сурвалж: Нийгмийн даатгалын газрын судалгаа

Нийгмийн даатгалын зарлага төлөвлөснөөс 509.6 сая төгрөгөөр хэмнэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 529.6 сая, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 103.2 сая төгрөгөөр буурсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зарлагын 529.5 сая төгрөгийн хэмнэлтэд өндөр насны тэтгэвэрт 178.9 сая, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт 278.3 сая, цэргийн албан хаагчийн тэтгэвэрт 71.2 сая, банкны үйлчилгээний хөлсөнд 14.9 сая төгрөгийн хэмнэлт тус тус гарсан нь голлон нөлөөлжээ.

Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлагын 103.2 сая төгрөгийн хэмнэлтэд хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэрт 36.0 сая, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 19.1 сая, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн тэтгэмжид 8.0 сая төгрөгийн хэмнэлт тус тус гарсан нь голчлон нөлөөлжээ.

Харин Тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 135.2 сая төгрөгөөр хэтэрсэн нь хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн тэтгэмж, эхийн хүүхэд асрах шимтгэл зэрэгт хэмнэлт гарсан боловч жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн зарлага 449.2 сая төгрөгөөр хэтэрснээс шалтгаалжээ. Үүнд: Нэг даатгуулагчид ногдох жирэмсэн болон амаржсаны дундаж тэтгэмж урд онтой харьцуулахад 1.1 сая төгрөгөөр буюу 43.9 хувиар өссөн болон

Нийгмийн даатгалын санд тайлагнасан дундаж цалин 2024 онд 1.2 сая төгрөг байсан бол 2025 онд 1.5 сая төгрөг болж өссөн нь нөлөөлжээ.

5.4. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн орлого төлөвлөснөөс 685.2 сая төгрөгөөр дутуу төвлөрсөн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого:

Эрүүл мэндийн даатгалын санд 12,061.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 11,376.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөө 685.2 сая төгрөгөөр буюу 5.7 хувиар тасарсан байна.

Хүснэгт 24. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого

№	Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого	10,835.0	10,287.7	-547.3
2	Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, суралцагчдын шимтгэлийн орлого	1,226.9	1,089.0	-137.9
Нийт		12,061.9	11,376.7	685.2

/сая.төг/

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.1.1, 6.1.11-д заасан эрүүл мэндийн даатгалд хамрагдах бүлгийн даатгуулагчийн шимтгэл, 19.1.8-д заасан шимтгэл, алдангийг цуглуулах, төвлөрүүлэх үйл ажиллагааг нийгмийн даатгалын байгууллага гүйцэтгэх бөгөөд үүнтэй холбогдсон харилцааг Нийгмийн даатгалын ерөнхий хуулиар зохицуулна”, 19.4 дэх хэсэгт “Нийгмийн даатгалын байгууллага төвлөрүүлсэн хөрөнгийг долоо хоног бүр эрүүл мэндийн даатгалын санд шилжүүлнэ” гэж заасан байдаг бөгөөд Нийгмийн даатгалын хэлтэст зарим ААН, төсвийн байгууллагууд нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын өртэй гарснаар ажил олгогч, даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөө бүрэн биелээгүй байна.

Түүнчлэн сум бүрд эрүүл мэндийн даатгал хариуцсан байцаагч, мэргэжилтэн байхгүй бөгөөд цахим системүүдийг ашиглан төлөх боломжтой, мөн 2016 оноос хойш мөрдсөн эрүүл мэндийн даатгалын шинэчилсэн хуулиар иргэн бүр эрүүл мэндийн даатгалд албан журмаар заавал даатгуулагч байхаар хуульчилснаар даатгуулагч иргэд хууль зүйн болон цахим систем ашиглалтын мэдлэг мэдээлэл дутмаг байдгаас шалтгаалан зөвхөн эрүүл мэндийн байгууллагад үзүүлж тусламж үйлчилгээ авах тохиолдолд эрүүл мэндийн даатгалын шимтгэлээ төлдөг зэрэг нөлөөлж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зардал:

Эрүүл мэндийн даатгалын сангаас 2025 оны гүйцэтгэлээр 49,327.8 сая төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 25. Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтыг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулалт

№	Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлагын төрөл	2024 он Гүйцэтгэл	2025 он Гүйцэтгэл	Зөрүү
1	Нэгдсэн эмнэлэг	18,755.1	20,948.8	2,193.7
2	Хувийн хэвшлийн эмнэлэг	1,192.1	623.3	-568.8
3	Эмийн сан /энгийн эм/	3,793.5	4,759.4	965.9
4	Эрт илрүүлэг /ЭМЯ/	661.9	417.2	-244.7
5	Өрхийн, сумдын ЭМТ /Өдрийн эмчилгээ, ОШ, СЗ, ГҮ/	1,572.6	1,260.7	-311.9
6	Төлбөрийн төр хариуцах эмийн санхүүжилт	37.3	83.5	46.2
7	ӨЭМТ-ийн анхан шатны санхүүжилт /Нэг иргэн/	1,758.7	1,908.5	149.8
8	СЭМТ-ийн анхан шатны санхүүжилт /Нэг иргэн/	12,376.0	14,787.2	2,411.2
9	СЭМТ-ийн Үндсэн тусламж үйлчилгээ /Хэвтэн, яаралтай, түргэн, шүдний амбулатори/	5,462.9	4,539.2	-923.7
Нийт		45,610.1	49,327.8	3,717.7

Эх сурвалж: Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн судалгаа

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалт өмнөх оноос 3,717.7 сая төгрөг буюу 8.1 хувиар өссөн байна. Уг өсөлтөд Нэгдсэн эмнэлэгт олгосон санхүүжилт 2,193.7 сая, сумдын Эрүүл мэндийн төвийн анхан шатны санхүүжилт 2,411.2 сая, Эмийн санд олгосон санхүүжилт 965.9 сая төгрөгөөр тус тус өссөн нь гол нөлөөг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт "Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын эрүүл мэндийн даатгалын сангаас болон даатгуулагчаас төлөх төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг эрүүл мэндийн даатгалын байгууллага болон санхүү, төсвийн, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Үндэсний зөвлөл тогтооно" гэж заасны дагуу 2025 онд зарим тогтоол шинэчлэгдэн батлагдсанаар Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнүүдийн үнэ тариф, зардлын төлбөрийн хэмжээ нэмэгдсэн нь сангийн зарцуулалт нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 04 дүгээр тогтоол,
2. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 03 дугаар тогтоол.

Мөн гэрээт эмийн сангуудын иргэн даатгуулагчдад олгосон хөнгөлөлттэй эмийн жорын тоо 2024 онд 83,002 байснаас 2025 онд 106,572 болж, 23,750 жороор нэмэгдсэн байна.

5.5. Орон нутгийн төсөвт байгууллагуудад 7,656.2 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламж 100.9 сая, Засгийн газрын нөөц сан /Засаг даргын нөөц хөрөнгө/-өөс 6,079.2 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,101.3 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 374.8 сая, нийт 7,656.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнээс: Урсгал зардалд 5,313.9 сая, хөрөнгийн зардалд 1,498.6 сая, нийт 6,812.5 сая төгрөгийг зарцуулж, зөрүү 843.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 26. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

№	Салбарын болон байгууллагын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2025 он	
			Санхүүжилт	Зарцуулалт
А	Б	1	2	3
1	Худалдан авах ажиллагааны газар		2.0	2.0
2	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба		2.0	2.0
3	Орон нутгийн өмчийн газар	4.9	10.6	10.6
4	Байгаль орчин аялал жуулчлалын газар	120.1	12.3	12.3
5	Аймгийн ИТХ	89.0	141.0	141.0
6	Аймгийн ЗДТГ	5,000.9	4,968.8	4,968.8
7	Баруунтуруун сум	74.2	4.4	4.4
8	Бөхмөрөн сум	119.2	92.6	92.6
9	Давст сум	101.2	201.8	201.8
10	Завхан сум	20.8	280.4	280.4
11	Зүүнговь сум	185.8	14.9	14.9
13	Зүүнхангай сум	195.6	4.4	4.4
14	Малчин сум	199.1	421.6	421.6
15	Наранбулаг сум	48.6	101.2	101.2
16	Өлгий сум	38.0	33.9	33.9
17	Өмнөговь сум	268.7	5.8	5.8
18	Өндөрхангай сум	62.5	23.3	23.3
19	Сагил сум	144.7	373.9	373.9
20	Тариалан сум	73.0	262.9	262.9
21	Түргэн сум	195.7	319.7	319.7
22	Тэс сум	279.4	308.0	308.0
23	Ховд сум	131.3	8.6	8.6
24	Хяргас сум	83.3	27.7	27.7
25	Цагаанхайрхан сум	60.3	7.4	7.4
26	Улаангом сум	155.6	27.0	27.0
	Нийт дүн	7,651.9	7,656.2	7,656.2

Эх сурвалж: ЗДТГ-ын СТСХ-ийн судалгаа

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт “Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна”, 11.5.4 дэх заалтад “энэ хуулийн 11.1-д заасан арга хэмжээг санхүүжүүлэхтэй холбоотой төсвийн жилийн дундуур баталсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх”, Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмын 2.2.1-д “шийдвэрийн төсөл нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 11.5-д заасан зориулалттай бүрэн нийцсэн болохыг танилцуулгад тодорхой тусгасан байх”, 2.2.2-д “урьдчилан тооцож төлөвлөх, эсхүл батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх боломжтой арга

хэмжээг тусгаагүй байх” гэж тус тус заасан байна.

Дээрх зохицуулалтын дагуу Засгийн газрын 2025 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 261 дүгээр тогтоолоор Маршал Юмжаагийн Цэдэнбалын хөшөө цогцолбор болон Увс аймгийн Улаангом суманд байрлах түүний нэрэмжит талбайг сэргээн засварлах төслийн ажилд зориулан 1,065.0 сая төгрөгийг, 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 27 дугаар тогтоолоор Увс аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан зохион байгуулах “Баруун бүсийн хөгжил-Увсад тавтай морил” арга хэмжээнд зориулан 1,250.0 сая төгрөгийг тус тус Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлэж, аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэн зарцуулсан байна.

5.6. Төрийн хэмнэлтийн тухай хууль зохих түвшинд хэрэгжиж байгаа ч хуулийн зарим зүйл заалттай холбоотой зөрчил байна.

Увс аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 03 дугаар “Төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах тухай” албан даалгавар гаргаж харьяа төсвийн захирагч нарт хүргүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт “Энэ хуулийн хэрэгжилтэд төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх байгууллага холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллана” гэж заасны дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, А/89 дүгээр тушаалаар баталсан “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ын дагуу Увс аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяаны төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчдын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 128.0 сая төгрөгийн 18 зөрчил илэрсэн. Үүнээс 11.1 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 102.6 сая төгрөгийн 12 зөрчилд албан шаардлага өгч, 14.3 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Үүнд:

8 дугаар зүйл. Дүрэмт хувцас

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж заасныг зөрчин аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бараа үйлчилгээний бусад зардлаас хурлын ажлын албан хаагчид, хурлын төлөөлөгчдэд 4 хос спорт хувцсыг 13.2 сая төгрөгөөр худалдан авсан зөрчилд зөвлөмж өгсөн.

12 дугаар зүйл. Бусад хангамж

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг зөрчсөн дараах 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд:

- Улаангом сумын Засаг даргын нөөц хөрөнгөнөөс иргэнд үзүүлсэн дэмжлэгийг Улаангом сумын Засаг даргын тамгын газрын нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас давхардуулан олгосон 1.5 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- “Чандмань-Увс” ХХК-ийн захирлын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/46 дугаар тушаалаар компанийн шинэ жилийн баярын цэнгүүний үйл ажиллагаанд зориулан 6.8 сая, 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдөр цэвэрлэх байгууламжийн Улаанбаатар хотоос ирсэн хүмүүст зориулж согтууруулах ундаа худалдан авахад 0.3 сая, нийт 7.1 сая төгрөгийг компанийн төсвөөс зарцуулсанд төлбөрийн акт тогтоосон.
- Түргэн сумын Засаг даргын 2025 оны А/05 дугаар захирамжаар хурлын төлөөлөгч нарт дэвтэр бал, хавтасны зардалд 1.1 сая төгрөгийн зардал гаргасан зөрчилд зөвлөмж өгсөн.

15 дугаар зүйл. Хэмнэлтийн бусад арга хэмжээ

Санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг 15.1.3, 15.1.4, 15.1.5, 15.1.7, 15.1.8, 15.2.7 дахь заалтуудыг зөрчсөн нийт 14 зөрчил илэрснээс 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 12 зөрчилд албан шаардлага өгсөн. Үүнд:

Харьяа байгууллагуудын аудитын илрүүлэлт:

- Бөхмөрөн сумын засаг даргын цалингийн зардлаас тухайн албан хаагчийн ажил үүрэгт хамааралгүй ажлын үр дүнг үнэлж Тамгын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар төрийн сангийн мэргэжилтэнд санхүүгийн аудитын шалгалтаар “зөрчилгүй” санал дүгнэлт авсан гэж 1.3 сая төгрөгийн урамшуулалт цалин олгосонд төлбөрийн акт тогтоосон.
- Түргэн сумын Засаг даргын тамгын газрын төсвийн хөрөнгөөр худалдан авсан архи, согтуурах ундааны 0.7 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварт гэж суутгасан 0.5 сая, нийт 1.2 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.
- Увс аймгийн Засаг даргын тамгын газар нь төсвийн хөрөнгөөр аймгийн 100 жилийн ойн үйл ажиллагаанд зориулж бэлгийн багц худалдан авахад 28.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- Улаангом сумын Засаг даргын тамгын газар нь төсвийн хөрөнгөөр 30.3 сая төгрөгийн бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- Бөхмөрөн сумын Засаг даргын 2025 оны А/177 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотын нутгийн зөвлөлийн дарга, тэргүүлэгчдэд бэлгийн багц худалдан авахад төсвөөс 0.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, “Хөх тэнгэрийн эсгий туургатан” НҮТББ-д сумын түүх, байгалийн үзэсгэлэнт газруудын тухай нэвтрүүлэг хийхэд зориулж Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/13 тушаалаар 3.0 сая, А/15 дугаар тушаалаар 1.0 сая, МБСТВ ХХК-д 2025 оны А/06 дугаар тушаалаар 1.5 сая, нийт 5.5 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
- Малчин сумын Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар Засаг даргын нөөц хөрөнгөөс Баянхайрхан уулын овооны тахилга зохион байгуулахад 3.3 сая, А/148 дугаар захирамжаар Улаанбаатар, Дархан хотын нутгийн зөвлөлтэй хамтран сумын түүхт 100 жилийн ойн баяр наадмын үр дүнгийн тайлан нэгтгэн дүгнэх арга хэмжээний үйл ажиллагааны зардалд 1.0 сая, А/105 дугаар захирамжаар Эх, үрсийн баярын арга хэмжээнд 1, 2 дугаар одон авсан эхчүүд болон уран, дархан бэр шагнаж урамшуулах, бэлэг дурсгалын зүйл авахад 2.0 сая, нийт 6.3 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- Сагил сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны А/03 дугаар тушаалаар бараа үйлчилгээний бусад зардлаас Хөвсгөл, Эрдэнэт, Дархан, Улаанбаатар хотод нутгийн зөвлөлийн уулзалтад зориулж бэлгийн багц худалдан авахад төсвөөс 1.5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- Тариалан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар захирамжаар Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлаас Үндсэн хуулийн өдөрт зориулсан бөхийн барилдааны шагналын зардалд 0.5 сая, 2025 оны 03 дугаар сарын

- 14-ний өдрийн 18 дугаар захирамжаар “Марш тактик”-ын тэмцээн зохион байгуулахад 0.5 сая, нийт 1.0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.
- Завхан сумын Засаг даргын 2025 оны А/13, А/19 дүгээр захирамжаар бэлэг дурсгалын зүйлд 1.3 сая төгрөг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
 - Түргэн сумын Засаг даргын тамгын газар нь Засаг даргын нөөц хөрөнгөөс сумын 100 жилийн ойн арга хэмжээ, уулзалт, бэлэг дурсгалын зүйлд 3.5 сая, Махардгийн овоо тахихад 3.2 сая, Засаг даргын тамгын газрын албан хаагчид ОХУ-ын Абакан хот руу явсан тээврийн хөлс 5.0 сая, нийт 11.7 сая төгрөгийг зарцуулсан зөрчилд албан шаардлага өгсөн.
 - Хяргас сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалаар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг Улаанбаатар хотод сургалтад суух, туршлага судлах ажлаар явахад ирж, очих унааны зардал гэж 4.0 сая төгрөгийг аж ахуйн нэгжийн дансаар дамжуулан гаргаж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсанд албан шаардлага өгсөн.
 - Улаангом политехник коллежийн захирлын 2025 оны А/35 дугаар тушаалаар биеийн тамирын уралдаан, тэмцээний зардалд 6.2 сая төгрөг зарцуулсанд албан шаардлага өгсөн.
 - Номын сангийн даргын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/25 дугаар тушаалаар төсвийн хөрөнгөөр 0.5 сая төгрөгийн бэлэг худалдан авсанд албан шаардлага өгсөн.
 - “Чандмань-Увс” ХХК-ийн гүйцэтгэх захирлын 2025 оны А/07, А/11, А/17, А/44 дүгээр тушаалуудаар тэмцээн уралдаан болон шинэ жилийн бэлэг өгөхөд компанийн төсвөөс 6.2 сая төгрөгийг зарцуулсанд албан шаардлага өгсөн.

5.7. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 126, байршуулаагүй 2, хугацаа хоцроосон 14, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 мэдээлэл байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө зарцуулсан шийдвэрийг мэдээлэх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй болон тайлант онд төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 14,751.9 сая төгрөгийн 115 шийдвэрийг байршуулаагүй зөрчилд албан шаардлага өгсөн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 43,276.9 сая төгрөгийн 19 зөрчил илэрснээс 15,049.0 сая төгрөгийн 11 зөрчилд албан шаардлага өгч, 28,227.9 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгсөн.

Хүснэгт 27. Харьяа байгууллагын аудитын илрүүлэлт

/сая.төг/

Д/д	ТӨЗ-ийн нэгтгэлийн ТШЗ, ТТЗ	Зөрчлийн тоо	Зөрчлийн дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ОНХС	1.0	5,915.1	1.0	5,915.1		
2	Аймгийн ЗДТГ	1.0	23,554.0			1.0	23,554.0
3	Бөхмөрөн сумын ТТЗ	1.0	1,023.9	1.0	1,023.9		
4	Тэс сумын ТТЗ	1.0	832.5	1.0	832.5		
5	Давст сумын ТТЗ	1.0	850.3	1.0	850.3		
6	Давст сумын ЗДТГ	1.0	47.6	1.0	47.6		
7	Давст сумын ИТХ	1.0	141.0	1.0	141.0		
8	Сагил сумын ТТЗ	1.0	390.1	1.0	390.1		
9	Цагаанхайрхан сумын ЗДТГ	1.0	2,491.1	1.0	2,491.1		
10	Цагаанхайрхан сумын ТТЗ	1.0	666.0	1.0	666.0		
11	Түргэн сумын ТТЗ	1.0	1,111.6	1.0	1,111.6		
12	Хяргас сумын ЗДТГ	1.0	1,579.8	1.0	1,579.8		
13	Чандмань-Увс ХХК	1.0	1,520.1			1.0	1,520.1
14	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар	1.0	8.2			1.0	8.2
15	Тариалан сумын ТТЗ	1.0	603.3			1.0	603.3
16	Завхан сумын ИТХ	1.0	85.6			1.0	85.6
17	Завхан сумын ЗДТГ	1.0	1,236.6			1.0	1,236.6
18	Завхан сумын ТТЗ	1.0	640.3			1.0	640.3
19	Увс аймгийн Халамжийн сан	1.0	579.8			1.0	579.8
	Нийт дүн	19.0	43,276.9	11.0	15,049.0	8.0	28,227.9

Эх сурвалж: СТА-ын зөрчлийн нэгтгэл

5.8. Өмнөх аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Орон нутгийн 2024 нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, судалгаа шинжилгээнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн нэгдсэн төсвийн 2025 оны орлого, зарлагыг өмнөх оны гүйцэтгэлд суурилан төлөвлөсөн байна.
2. Орон нутгийн 2025 оны татварын орлогыг төлөвлөснөөс 2,217.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.
3. Аймгийн нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөснөөс 7,238.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.
4. Орон нутгийн нэгдсэн төсвийн нийт тэнцэл (2,930.9) сая төгрөг байна.
5. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2025 онд Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 90.4 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.
6. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 37 дугаар “Аймгийн 2025 оны төсөвт зохицуулалт хийх тухай” тогтоол гаргаж аймгийн 2025 оны төсвийн орлого, зарлагыг 370.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ОНХС болон их засвар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд өөрчлөлт оруулан баталсан байна.
7. Сангийн яамнаас ирүүлсэн Увс аймгийн төсөвт төвлөрүүлэх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 40 хувийн орлогын хэмжээ 2,000.0 сая төгрөг байсныг 186.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 онд хэрэгжүүлэх 35 хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтад аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 5 төсөл, арга хэмжээг баталсан байна

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Увс аймгийн Засаг даргад:

1. Төсөвт зохицуулалт хийхдээ Төсвийн тухай хуулийн 42.4, 42.7 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст:

1. Сангийн яамнаас ирүүлсэн төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийг мөрдөж ажиллах.

Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэст:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6.10.4 дэх заалтад “Орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасныг мөрдөж ажиллах.

ХЯНАСАН: АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.НАМЖИЛ

АУДИТОР
АУДИТОР

Т.АМАРМЭНД
Т.БАТСҮХ